



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 3/02

Хэрлэн сум

Д.Пүрэвжавыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.20, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Улсын Их Хурлын байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Доржийн Пүрэвжав нь удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад орж тэнцсэн тул Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан тушаалд 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын

дарга: С.Нямдаваа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Цэцэгсүрэн

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн
төсвийн ерөнхий нягтлан бодогч

D:\My Documents\Захирамж-2024

231010183

Б.Шажинбат


2.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, Дотоод аудитор

3.Д.Пүрэвжавын үндсэн цалинг ТЗ-4 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалин 1757000 /нэг сая долоон зуун тавин долоон мянга/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 18 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг 20 хувиар, өдрийн хоолны хөнгөлөлтийг 15,000 төгрөгөөр тус тус тооцож олгохыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Пүрэвжавд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ